

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

| | |
|---|----|
| 1. Аудитын гэрчилгээ | 2 |
| 2. Аудитын тайлан..... | 4 |
| 2.1. Оршил..... | 4 |
| 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага | 4 |
| 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт | 4 |
| 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин..... | 4 |
| 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ | 5 |
| 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал..... | 5 |
| 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар..... | 5 |
| 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд..... | 6 |
| 2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар тодруулга | 7 |
| 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн | 8 |
| 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал..... | 8 |
| 2.12. Шилэн дансны мэдээлэл | 8 |
| 2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт..... | 8 |
| 2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл..... | 8 |
| 3. Менежментийн захидал | 9 |
| 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан | 11 |
| 4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 11 |
| 4.2. Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан | 12 |
| 4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан..... | 13 |
| 4.4. Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан..... | 14 |
| 5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт | 15 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---------|--|
| ЭАР ХХК | Эрдэнэс Алт Ресурс ХХК /компанийн дүрэмд заасан/ |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| БОННУ | Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ |
| ТЭЗҮ | Техник эдийн засгийн үндэслэл |
| НБББББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.АЧИТСАЙХАН ТАНАА

2020.03.13 № 06/836
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудит хийх журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

“Эрдэнэс Алт Ресурс” ХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

“Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Гүйцэтгэх захирал Б.Ачитсайхан Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, тайлагнал, санхүүгийн программ хангамж, анхан шатны баримтын бүрдлийг сайжруулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журам, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, арга зүйн дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Гүйцэтгэх удирдлага нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журам, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, арга зүйн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 17-ноос 2020 оны 3 дугаар сарын 12-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 16-ны өдөр эцэслэн баталгаажуулж, гүйцэтгэх удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар Нью Эстимэйтор Аудит ХХК-ийн захирал Т.Бүжидмаа удирдаж, партнер Ж.Үхэртар хяналт хэрэгжүүлж, аудитор Д.Баяраа, шинжээч Б.Халиунаа, аудиторын туслах Ү.Алтанзул нар хариуцаж хэрэгжүүлэв.

“Эрдэнэс Алт Ресурс” ХХК нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2020 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн ЕА-20/21 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“Эрдэнэс алт ресурс”-ийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Байгалийн баялгийг удирдаж, үнэ цэнэ, үр өгөөжийг бий болгоход оршино.

Үйл ажиллагааны чиглэл:

“Эрдэнэс алт ресурс” ХХК нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үнэт металл эрэх, хайх, олборлох, цэвэршүүлэх, борлуулах чиг үүрэг бүхий аж ахуйн нэгж байх юм. Геологи хайгуулын ажил гүйцэтгэж улсын алт, мөнгөний нөөцийг нэмэгдүүлэх, олборлолтын хэмжээг өсгөх, үнэт металлыг олон улсын стандартын дагуу Монголд цэвэршүүлэх, эрдэнэсийн санг арвижуулах, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, Монгол Улсын зээлжих зэргийг өсгөх томоохон зорилтын хүрээнд уг компанийг байгуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд НДШ, Татварын багц /ХХОАТ, ААНОАТ.../ гэх мэт хуулиудад өөрчлөлт орсон байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Толгой компани болох “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 45 дугаар тогтоолоор “Эрдэнэс Монгол” ХХК болон охин компаниудын хэмжээнд дагаж мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2017 онд баталсан тул Сангийн яамнаас 2018 оноос хойших хугацаанд батлагдан гарч хэрэгжүүлж байгаа холбогдох зарим стандарт, хууль тогтоомжийн өөрчлөлтийг бодлогын баримт бичигт оруулж шинэчлэн өөрчлөөгүй байна.

“Эрдэнэс Алт Ресурс” ХХК нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Ритус ХХК-ийн МУ-ын зохиогчийн эрхийн 2010/229 дугаар гэрчилгээтэй, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2010 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 12 тоот тушаалаар программ ашиглах эрхийн гэрчилгээтэй, “Ноён” санхүүгийн программ хангамжийг ашигладаг байна.

“Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад санхүүгийн анхан шатны баримтын бүрдлийг хангасан, авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулсан, эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн тооллого явуулж, тооцоог хийсэн зэрэг ахиц гарсан байна.

Толгой болон охин компанийн санхүүгийн албад хоорондын тайлан мэдээ, бүртгэл тооцоо сайн хийгддэг байна. Харин Толгой компанийн Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгддэг ч хяналт шалгалт хийсэн талаарх тайланг ирүүлээгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар “Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 4 чиглэлд 12 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитын төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн тайлангийн нийт хөрөнгийг сонгон материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тооцож, урьдчилсан байдлаар материаллаг байдлын түвшинг 15.1 сая төгрөгөөр тодорхойлж, баталгаажуулсан.

Төлөвлөлтийн үе шатанд 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн хөрөнгийн дүнгээс тооцсон бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд жилийн эцсийн тайлангийн дүнгээс тооцсон тул материаллаг байдлын түвшин 4.1 сая төгрөгөөр нэмэгдэж, 19.2 сая төгрөгөөр тодорхойлогдов.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,879.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмч, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | /сая төгрөг/ | | |
|---|----------------|-----------------|----------------|
| | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 4.5 | 259.1 | 254.5 |
| Авлага | 2.5 | 7.9 | 5.4 |
| Урьдчилгаа | 9.5 | 0.02 | -9.4 |
| Бараа материал | - | 1.2 | 1.2 |
| Үндсэн хөрөнгө | 22.8 | 1,444.3 | 1,421.4 |
| Нийт хөрөнгө | 39.4 | 1,918.5 | 1,879.1 |
| Өр төлбөр | 5.4 | 2,540.7 | 2,535.3 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 34.0 | -622.2 | -656.2 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 39.4 | 1,918.5 | 1,879.1 |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 254.5 сая төгрөгөөр өссөн нь 2019 онд батлагдсан төлөвлөгөөний дагуу санхүүжилтийг бүрэн олгосон ба гүйцэтгэлийн хувьд үйл ажиллагаанаас нийт 301.2 сая, хөрөнгө оруулалтаас 72.9 сая, нийт 374.3 сая төгрөгийн үнийн зөрүүгийн хэмнэлт болон дутуу санхүүжилт гарсантай холбоотой байна. Үүнд:

1. Суудлын автомашин худалдан авахад 200.0 сая төгрөгийг баталж, 172.5 сая төгрөгөөр худалдан авсны зөрүү 27.5 сая төгрөгийн хэмнэлт;
2. АЦҮ-ийн БОННУ-ний төслийн ажилд 150.0 сая төгрөг баталснаас 127.8 сая төгрөгөөр гүйцэтгэсэн;
3. АЦҮ-ийн дэд бүтцийн судалгааны төслийн хувьд 110.0 сая төгрөг зарцуулахаар батлагдсанаас 97.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй;
4. Оффисын засварын зардалд 22.0 сая төгрөг баталснаас 12.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан зэргээс шалтгаалсан байна.

Биет хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь Толгой компани болох “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор Толгой болон охин компаниудын 2019 оны төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодотгол хийсэн, мөн “Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор баталсан төлөвлөгөө зэргийг үндэслэн 1,439.5 сая төгрөгийн биет хөрөнгө худалдан авснаас шалтгаалжээ. Үүнд:

1. Дуусаагүй барилга буюу алт цэвэршүүлэх үйлдвэртэй холбоотой ТЭЗҮ. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, дэд бүтцийн гэсэн төслийн гүйцэтгэлийг хүлээн авсан 1,238.4 сая төгрөг; /төрийн маш нууцад хамааралтай/
2. Автомашин 1 ширхэг – 172.5 сая төгрөг; -тендер
3. Тавилга, эд хогшил -14.3 сая төгрөг;
4. Тоног төхөөрөмж – 14.4 сая төгрөг нийт 1,439.5 сая төгрөг болно.

Биет бус хөрөнгө

2019 онд газрын дуудлага худалдаагаар 178.3 сая төгрөгийн газар худалдан авсан.

Мөн тендерээр 34.5 сая төгрөгөөр /нууцын зэрэглэлтэй/ геологийн мэдээллийн сангийн программ, 1.9 сая төгрөгөөр санхүүгийн программыг тус тус худалдан авсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь “Эрдэнэс Монгол” ХХК-иас авсан зээл, зээлийн хүүгийн өглөг, төслийн тооцооны төлбөр зэргээс шалтгаалжээ. Үүнд:

1. Глобал Энвайрон ХХК- БОННУ төслийн үлдэгдэл нийт өр төлбөрийн 1.0% буюу 25.5 сая төгрөгөөр;
2. Инж байгууламж ХХК- дэд бүтцийн төсөл – 1.1% буюу 29.2 сая төгрөг;
3. Аюуд проперти ХХК-д цэвэрлэгээ -0.01%-0.02 сая төгрөг;
4. Жам ХХК-д гэрээт ажил-0.2%-6.0 сая төгрөг;
5. Эрдэнэс Монгол ХХК-д санхүүжилт буюу богино хугацаат зээлийн өглөгийн хувьд нийт төлбөрийн 91.9% буюу 2,334.3 сая төгрөг;
6. Зээлийн хүүгийн өглөг 5.4% буюу 137.8 сая төгрөг нийт 2,540.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна. Дээрх тооцооны үлдэгдлийг баталгаажуулж акт үйлдсэн байна.

2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар тодруулга

Хүснэгт 2. 2019 оны бизнес төлөвлөгөө, гүйцэтгэл

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | /сая төгрөгөөр/ | |
|----|--|----------------|----------------|-----------------|-------------|
| | | | | Зөрүү | Хувь |
| 1 | Компанийн өөрийн үйл ажиллагааны зардал | 443.5 | 391.0. | 52.4 | 11.8 |
| 2 | Компанийн хөрөнгө оруулалт | 231.3 | 203.2 | 28.1 | 12.2 |
| | ДҮН | 674.8 | 594.2 | 80.6 | 11.94 |
| 3 | Төслийн үйл ажиллагаанд | 361.8 | 113.0 | 248.9 | 68.8 |
| 4 | Төслийн хөрөнгө оруулалт программ | 43.0 | 34.6 | 8.5 | 19.7 |
| 5 | Төслийн /газар | 178.4 | 178.4 | - | - |
| 6 | АЦҮ ТЭЗҮ | 1,005.0 | 1,003.2 | 1.8 | 0.2 |
| 7 | АЦҮ БОННУ | 150.0 | 127.8 | 22.2 | 14.8 |
| 8 | Төслийн үйлдвэрлэлийн дэд бүтцийн судалгааны төсөл | 110.0 | 97.6 | 12.4 | 11.3 |
| 9 | Төслийн дүн | 1,848.2 | 1,554.5 | 293.7 | 15.9 |
| 10 | Бүгд | 2,523.0 | 2,148.7 | 374.3 | 14.8 |

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн “Толгой болон охин компаниудын 2019 оны төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний тодотгол батлах тухай” 11 дүгээр тогтоолоор “Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн 2019 оны төлөвлөгөөнд биет бус хөрөнгийг санхүүжүүлэхээр 480.0 сая төгрөгийг нэмж тодотгосон байна.

Харин “Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор 2019 оны батлагдсан төлөвлөгөөний нийт дүнг өөрчлөхгүйгээр дотор нь 68.4 сая төгрөгийн зохицуулалтыг толгой компанийн зөвшөөрлөөр өөрчлөн баталсан байна.

“Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн үйл ажиллагааны зардалд 443.5 сая, хөрөнгө оруулалтын зардалд 231.3 сая нийт 674.8 сая төгрөг баталж, гүйцэтгэлээр үйл ажиллагааны зардалд 391.0 сая, хөрөнгө оруулалтаар 203.2 сая нийт 594.2 сая төгрөг зарцуулжээ.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 12 эрсдэл тогтоож гүйцэтгэх үе шатанд шинээр эрсдэл нэмж тодорхойлоогүй бөгөөд нийт 16 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар илэрсэн залруулагдаагүй алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3-н зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар төслийн ажил дууссан үеийн анхан шатны баримтын бүрдлийг нарийвчлан шалгах шаардлагатай гэж үзэж байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д хамаарах байгууллага юм. “Эрдэнэс алт ресурс” ХХК нь Шилэн дансны тухай хуулийн 6.8 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллага шилэн дансны мэдээллээр хөрөнгө оруулалт тендер, худалдан авалттай холбоотой мэдээлэл 26 удаа, бусад мэдээллийг 36 удаа тус тус мэдээлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8-д заасны дагуу нийт 62 мэдээллийг байршуулснаас 31 мэдээллийг хугацаанд нь, 31 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Шилэн дансны системд 2019 оны 03 дугаар сард бүртгүүлэхэд бүртгэлийг өөр ангилалд оруулсан байсныг 09 сарын 02-ны өдрөөс ангиллыг засаж бүртгүүлсэн байна.

Өмнөх буруу ангиллаас хамаарч зарим оруулах мэдээлэл зөрүүтэй байснаас “хугацаа хоцорсон” гэсэн ангилалд орсон байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 5 зөвлөмж өгснийг 100% хэрэгжүүлж ажилласан байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

“Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, СТОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Тус компанийн дагаж мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох зарим хууль, эрх зүйн, актын өөрчлөлтийг тусгаж шинэчлэн өөрчлөөгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана”-гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, холбогдох хууль, тогтоомж, заавар, журмыг мөрдөж ажиллахгүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

НБББББ-т санхүү, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой хууль, эрх зүйн актуудын өөрчлөлтийг оруулах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

"Эрдэнэс Монгол" ХХК-ийн удирдлага болон өөрийн компанийн ТУЗ-д асуудал болгон оруулж өөрчлөхийг зөвшөөрөв.

3.2 Эрх бүхий байгууллагын зөвшөөрөл, үнэлгээтэй Санхүүгийн программ хангамжийг ашиглах.

3.2.1 Илрүүлэлт:

Тус байгууллагад хэрэглэж байгаа “Ноён” санхүүгийн программ нь Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2010 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 12 тоот тушаалаар программ ашиглах эрхийн гэрчилгээг 2 жилийн хугацаатайгаар авсан ч хугацаа нь дууссан, Нягтлан бодох бүртгэлийн хүрээлэнгийн үнэлгээнд хамрагдаагүй байна

3.2.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангахгүй байх эрсэлтэй.

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын баталсан 2017 оны 13 дугаар тушаалын дагуу зөвшөөрөлтэй, Нягтлан бодох бүртгэлийн хүрээлэнгийн дүгнэлттэй программ хангамжийг ашиглах

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Программ хангамжийн компанийн удирдлагуудтай уулзаж, хэрвээ зөвшөөрөлгүй, үнэлгээ нь хангалтгүй бол татгалзах.

3.3 Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулахтай холбоотой төслийн ажлын гүйцэтгэлийн баримт бүрдлийн талаар

3.3.1. Илрүүлэлт:

Дуусаагүй барилга дансанд бүртгэгдсэн Төрийн нууцад хамаарал бүхий төслийн ажлуудыг хүлээн авах тухай дээд шатны удирдах байгууллагын шийдвэр гарсан хэдий ч төслийн зарим баримтууд эцэслэгдэн ирээгүйгээс бүрэн хүлээж аваагүй байна.

3.3.2. Эрсдэл:

Төслийн бүрэн болон хэсэгчлэн дууссан ажлуудын гүйцэтгэлийг хүлээн авсан акт, бусад холбогдох баримтууд дутуу байх нь санхүүгийн болон техник, үйлчилгээний засвар хийх, өргөтгөл хийж шинэчлэх ... гэх мэт хүлээгдэх ажлыг гүйцэтгэхэд эрсдэл үүсэх магадлалтай.

3.3.3. Өгсөн зөвлөмж:

Дээд шатны байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлж төслийн гүйцэтгэлийн баримтуудыг бүрэн гүйцэт хүлээн авах.

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Төслийн ажлын гүйцэтгэлийг хүлээн авах цаг хугацаанд анхан шатны баримтыг бүрдүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | 2018 оны 12-р сарын 31 | 2019 оны 12-р сарын 31 |
|-----------------|--|------------------------|-------------------------|
| 1 | ХӨРӨНГӨ | | |
| 1.1 | Эргэлтийн хөрөнгө | | |
| 1.1.1 | Мөнгөн түүнтэй адилтгах хөрөнгө | 4,580,556.66 | 259,148,753.48 |
| 1.1.2 | Дансны авлага | 2,542,750.00 | |
| 1.1.4 | Бусад авлага | | 7,974,295.60 |
| 1.1.6 | Бараа материал | | 1,209,880.00 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 9,500,000.00 | 289,975.00 |
| 1.1.11 | Эргэлтийн хөрөнгийн дүн | 16,623,306.66 | 268,622,904.08 |
| 1.2 | Эргэлтийн бус хөрөнгө | | |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 22,838,972.00 | 1,444,335,164.35 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | | 205,618,166.54 |
| 1.2.10 | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 22,838,972.00 | 1,649,953,330.89 |
| 1.3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 39,462,278.66 | 1,918,576,234.97 |
| 2 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ | | |
| 2.1 | Өр төлбөр | | |
| 2.1.1 | Богино хугацаат өр төлбөр | | |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 2,880,000.00 | 61,133,533.00 |
| 2.1.1.3 | Татварын өр | 846,620.85 | 7,459,057.96 |
| 2.1.1.4 | НДШ-ийн өглөг | 1,686,800.00 | |
| 2.1.1.5 | Богино хугацаат зээл | | 2,334,343,461.20 |
| 2.1.1.6 | Хүүний өглөг | | 137,835,620.59 |
| 2.1.1.13 | Богино хугацаат өр төлбөрийн дүн | 5,413,420.85 | 2,540,771,672.75 |
| 2.1.2 | Урт хугацаат өр төлбөр | - | - |
| 2.2 | Өр төлбөрийн нийт дүн | 5,413,420.85 | 2,540,771,672.75 |
| 2.3 | ЭЗДИЙН ӨМЧ | | |
| 2.3.1 | Өмч: а) төрийн | | 100,000.000.00 |
| 2.3.2 | б) хувийн | 100,000.000.00 | |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг, алдагдал | (65,951,142.19) | (722,195,437.78) |
| 2.3.11 | Эздийн өмчийн дүн | 34,048,857.81 | (622,195,437.78) |
| 2.4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН | 39,462,278.66 | 1,918,576,234.97 |

4.2. Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | 2018 оны 12-р сарын 31 | 2019 оны 12-р сарын 31 |
|------------|--|------------------------|------------------------|
| 1 | Борлуулалтын орлого/цэвэр/ | | |
| 2 | Борлуулалтын өртөг | | |
| 3 | Нийт ашиг/алдагдал | | |
| 5 | Хүүний орлого | 2,152,847.16 | 3,463,994.44 |
| 8 | Бусад орлого | | 49,500.00 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 66,691,690.47 | 524,797,089.98 |
| 11 | Санхүүгийн зардал | | 137,835,620.59 |
| 12 | Бусад зардал | 1,197,014.21 | 6,581,830.00 |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз /гарз/ | | 9,803,149.98 |
| 18 | Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | (65,735,857.52) | (655,897,896.15) |
| 19 | Орлогын татварын зардал | 215,284.72 | 346,399.44 |
| 20 | Татварын дараах ашиг (алдагдал) | (65,951,142.24) | (656,244,295.59) |
| 22 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | (65,951,142.24) | (656,244,295.59) |

4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | 2018 оны 12-р сарын 31 | 2019 оны 12-р сарын 31 |
|------------|---|------------------------|---------------------------|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 1.1 | Мөнгөн орлогын дүн | | 49,500.00 |
| 1.1.6 | Бусад мөнгөн орлого | | 49,500.00 |
| 1.2 | Мөнгөн зарлагын дүн | 61,447,013.47 | 1,600,122,691.85 |
| 1.2.1 | Ажилчдад төлсөн | 26,589,586.00 | 183,504,137.52 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 5,397,500.00 | 53,589,059.72 |
| 1.2.3 | Түүхий материал худалдан авахад төлсөн мөнгө | 454,770.00 | 10,013,509.00 |
| 1.2.4 | Ашиглалтын зардалд төлсөн | 20,954,062.00 | |
| 1.2.5 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 1,000,000.00 | 8,708,750.00 |
| 1.2.7 | Татварын байгууллагад төлсөн | 2,354,100.00 | 16,569,830.18 |
| 1.2.8 | Даатгалын төлбөрт төлсөн | | 2,543,304.00 |
| 1.2.9 | Бусад мөнгөн зарлага | 4,696,995.47 | 1,325,194,101.43 |
| 1.3 | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (61,447,013.47) | (1,600,073,191.85) |
| 2 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 2.1 | Мөнгөн орлогын дүн | 2,152,847.13 | 12,366,129.27 |
| 2.1.5 | Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | | 8,902,134.83 |
| 2.1.6 | Хүлээн авсан хүүний орлого | 2,152,847.13 | 3,463,994.44 |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн | 33,480,727.00 | 492,068,201.80 |
| 2.2.1 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 23,980,727.00 | 201,170,404.00 |
| 2.2.2 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | | 214,890,000.00 |
| 2.2.5 | Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгаа | 9,500,000.00 | 76,007,797.80 |
| 2.3 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн | (31,327,879.87) | (479,702,072.53) |
| 3 | Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 3.1 | Мөнгөн орлогын дүн | | 2,334,343,461.20 |
| 3.1.1 | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | | 2,334,343,461.20 |
| 3.2 | Мөнгөн зарлагын дүн | 2,644,550.00 | |
| 3.2.1 | Зээл авсан, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | 101,800.00 | |
| 3.2.2 | Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн мөнгө | 2,542,750.00 | |
| 3.3 | Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн | (2,644,550.00) | 2,334,343,461.20 |
| 4 | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | (95,419,443.34) | 254,568,196.82 |
| 5.1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 100,000,000.00 | 4,580,556.66 |
| 5.2 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 4,580,556.66 | 259,148,753.48 |

4.4. Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайланТайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөг/

| | Үзүүлэлт | Өмч | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|-----------|--|-----------------------|-------------------------|-------------------------|
| 1 | 2018 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл | 100,000,000.00 | (65,951,142.19) | 34,048,857.81 |
| 3 | Залруулсан үлдэгдэл | 100,000,000.00 | (65,951,142.19) | 34,048,857.81 |
| 11 | 2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 100,000,000.00 | (65,951,142.19) | 34,048,857.81 |
| 13 | Залруулсан үлдэгдэл | 100,000,000.00 | (65,951,142.19) | 34,048,857.81 |
| 18 | Тайлант үеийн цэвэр ашиг | | (656,244,295.59) | (656,244,295.59) |
| 21 | 2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 100,000,000.00 | (722,195,437.78) | (622,195,437.78) |

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | |
|--|---|--|
| Огноо: 2020.03.10 | Аудитын нэр: Эрдэнэс Алт Ресурс ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит | Аудитын код: САГ-2020/89/СТА-ТӨҮГ |
| Шалгагдсан байгууллагын нэр: Эрдэнэс Алт Ресурс ХХК | сая төгрөгөөр | |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|--|------------|---------------------------------------|---|----------------------------|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| 1 | | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Тус компанийн дагаж мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох зарим хууль, эрх зүйн, актын өөрчлөлтийг тусгаж шинэчлэн өөрчлөөгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалттай нийцэхгүй байна. | - | Зөвлөмж өгөх | Нягтлан бодогч | Л.Сайнбаяр |
| 2 | Тус байгууллагад хэрэглэж байгаа “Ноён” санхүүгийн программ Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2010 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 12 тоот тушаалаар программ ашиглах эрхийн гэрчилгээг 2 жилийн хугацаатайгаар авсан ч хугацаа нь дууссан, Нягтлан бодох бүртгэлийн хүрээлэнгийн үнэлгээнд хамрагдаагүй байна. | - | Зөвлөмж өгөх | Нягтлан бодогч | Л.Сайнбаяр |
| 3 | Дуусаагүй барилга дансанд бүртгэгдсэн Төрийн нууцад хамаарал бүхий төслийн ажлуудыг хүлээн авах тухай дээд шатны удирдах байгууллагын шийдвэр гарсан хэдий ч төслийн зарим баримтууд эцэслэгдэн ирээгүйгээс бүрэн хүлээж аваагүй байна. | - | Зөвлөмж өгөх | Нягтлан бодогч Нууцын ажилтан | Л.Сайнбаяр А.Намхайдорж |
| | Дүн | - | | | |